

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны

13 дугаар сарын 18-ны өдөр



БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ,
АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ДЭД
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Г.МАРТ

2024.03.12

Сайншанд

№	Үйл ажиллагааны чиглэл	Санхүүжилт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн	Хамтрах талууд
1. Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд					
1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг www.mtram.gov.mn цахим хуудсаар дамжуулан шинэчлэх	-	Сар бүр	ХБТХОХ	Зөвлөлийн гишүүд
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, өөрчлөлт, тайлан, зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн мэдээ, тайланг компани тус бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх	-	II, IV улиралд	Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга	Сумдын Засаг дарга
3	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр хандив, дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж	-	4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор	Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга	Татварын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын Засаг дарга

	оруулан нэгдсэн дүнг ОУИТБСА-ын албанд хүргүүлэх				
4	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн мэдээ тайлан гаргах, Гэрээний ил тод байдлын цахим санд шинээр байгуулсан гэрээг оруулах	-	II, IV улиралд	Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга	Сумдын Засаг дарга, ГХБХБГ, БОАЖГ, сав газрын захиргаад
5	"Нөхөн сэргээлт-2024" төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	-	Сар бүр	Дэд зөвлөл	Сумдын Засаг дарга, ГХБХБГ, БОАЖГ, ЦГ,
6	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн судалгааг нарийвчлан гаргаж, танилцуулга мэдээллийн цахим баазыг бүрдүүлэх	-	II улиралд	Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга	Сумдын Засаг дарга, ГХБХБГ, БОАЖГ, сав газрын захиргаад
2.Иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд					
1	2023 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамжийн орлогын тайланг аймгийн dotgov.i.gov.mn цахим хуудас болон сонин, сэтгүүл, мэдээ байршуулж нийтэд мэдээлэх	-	II улиралд	Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга	Аймгийн ЭДТГ, сумдын Засаг дарга нар
3.Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд					
1	Сумдын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх дэд зөвлөлийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах	500.0	III улиралд	Дэд зөвлөл	Сумдын Засаг дарга нар, Дэд зөвлөл
2	2023 онд хийгдсэн Хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэх, сумдын Засаг дарга нартай ус, хог, газар ашиглах, эзэмших гэрээний биелэлтийг дүгнэх Хамтын ажиллагааны хороог байгуулж, уг ажлыг гүйцэтгэх	500.0	II улиралд	Дэд зөвлөл	Аймгийн ЭДТГ, сумдын Засаг дарга нар

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:
 АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД
 БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
 БИЧГИЙН ДАРГА Х.ОТГОНЖАРГАЛ

